

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тэс сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/149/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаангом хот
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
Гэрээт аудитор: С.Алтанхундага
Утас: 70453799, Цахим хаяг: S_Altanhundaga@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	
Асуудлыг онцолсон хэсэг	
Аудитын гол асуудал.....	
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	
4.1 Ерөнхий зүйл	
4.2 Материаллаг байдал.....	
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	
4.5.1 Завсрын аудитын талаар	
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	
5.1 Залруулсан алдаа	
5.2 Төлбөрийн акт	
5.3 Албан шаардлага	
5.4 Зөвлөмж.....	
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шүүд захирагч
НА	Нийцлийн аудит



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

ТЭС СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 2 ДУГААР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Ж.ОЮУН ТАНАА

2023.02.24 № УВА-2023/149/НА-СӨА-ТШЗ
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тэс сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тэс сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант хугацаанд Тэс сумын ИТХ-ын 2022 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 8/04 дүгээр тогтоолоор 30 ширхэг тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил, бусад үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

0200700598

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>48,402,804.00</u>	<u>83,406,300.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	34,423,899.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	34,423,899.00
3121	Төгрөг	00.00	34,423,899.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	34,423,899.00
33	АВЛАГА	215,772.00	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	215,772.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	48,187,032.00	48,982,401.00
351	Түүхий эд материал	410,650.00	264,799.00
35130	Эм боох материал	410,650.00	264,799.00
354	Хангамжийн материал	47,776,382.00	48,717,602.00
35410	Бичиг хэргийн материал	1,189,550.00	1,746,500.00
35420	Аж ахуйн материал	10,106,500.00	10,273,000.00
35440	Түлш, шатах тослох материал	17,966,640.00	12,800,000.00
35460	Хүнсний материал	11,389,817.00	16,774,227.00
35470	Бусад хангамжийн материал	7,123,875.00	7,123,875.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>533,575,932.96</u>	<u>499,359,468.97</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	533,575,932.96	499,359,468.97
392	Биет хөрөнгө	512,503,732.96	478,287,268.97
39201	Барилга, байгууламж, орон сууц	697,487,745.97	697,487,745.97
39202	Хуримтлагдсан элэгдэл	-212,747,529.24	-245,977,018.32
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	58,287,524.00	51,694,257.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-48,498,021.12	-41,825,705.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	30,640,797.48	25,587,135.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	-14,543,788.63	-12,166,840.39
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,089,500.00	1,365,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-731,166.50	-364,016.65
39217	Ном	1,518,671.00	2,486,210.76
393	Биет бус хөрөнгө	21,072,200.00	21,072,200.00
39303	Бусад биет бус хөрөнгө	21,072,200.00	21,072,200.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>581,978,736.96</u>	<u>582,765,768.97</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>581,978,736.96</u>	<u>582,765,768.97</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	581,978,736.96	582,765,768.97
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	48,366,231.95	48,366,231.95
51101	Өмч: - төрийн	48,366,231.95	48,366,231.95
512	Хуримтлагдсан үр дүн	161,295,267.86	162,082,299.87
51210	Өмнөх үеийн үр дүн	161,295,267.86	161,295,267.86
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	787,032.01

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	372,317,237.15	372,317,237.15
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	581,978,736.96	582,765,768.97

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн дүн

Дансны код	Үзүүлэлт	/төгрөг/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	289,983,969.00	364,544,339.76
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	927,539.76
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	927,539.76
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	927,539.76
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	927,539.76
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	30,757,369.00	363,616,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	309,350,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	309,350,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	259,226,600.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,557,369.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,557,369.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	26,200,000.00	54,266,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	26,200,000.00	54,266,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	315,978,915.27	363,757,307.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	304,428,853.27	350,360,665.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	304,428,853.27	350,360,665.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	203,361,911.00	220,446,264.79
210101	Үндсэн цалин	124,141,084.00	164,317,738.79
210102	Нэмэгдэл	51,714,571.00	43,209,947.00
210104	Урамшуулал	11,173,749.00	12,918,579.00
210105	Гэрээт ажлын хөлс	16,332,507.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,058,323.00	27,401,285.21
210201	Тэтгэврийн даатгал	18,220,327.87	19,596,886.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,221,072.97	2,878,774.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	977,158.36	1,394,761.74
210204	Ажилгүйдлийн даатгал	187,364.18	288,597.42
210205	Эрүүл мэндийн даатгал	3,452,399.62	3,242,265.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,059,678.00	28,954,356.00
210301	Гэрэл, цахилгаан	1,957,678.00	2,398,356.00
210302	Түлш, халаалт	11,012,000.00	26,456,000.00
210303	Цэвэр, бохир ус	90,000.00	100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,630,919.00	3,481,540.00
210401	Бичиг хэрэг	717,369.00	156,000.00

210402	Тээвэр, шатахуун	604,750.00	2,613,540.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	367,000.00	200,000.00
210404	Ном, хэвлэл	50,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	298,800.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,593,000.00	512,000.00
2105	Нормативт зардал	11,428,830.00	17,230,916.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	685,960.00	145,851.00
210502	Хоол, хүнс	8,927,870.00	16,379,065.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,815,000.00	706,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,305,000.00	480,000.00
210604	Урсгал засвар	1,305,000.00	480,000.00
2107	Томилолт, зочны зардал	241,600.00	306,000.00
210702	Дотоод албан томилолт	241,600.00	306,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,723,000.00	1,504,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,150,000.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	108,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	465,000.00	1,504,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45,619,592.27	50,556,303.75
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	7,739,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,600,600.00	1,529,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	42,018,992.27	41,287,503.75
210904	Найдваргүй авлагын алдагдал	00.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,550,062.00	13,396,642.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,113,800.00	12,788,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,713,800.00	9,458,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,000.00	3,330,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,436,262.00	608,442.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,436,262.00	608,442.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-25,994,946.27</u>	<u>787,032.01</u>
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-25,994,946.27</u>	<u>787,032.01</u>

2.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөг/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>289,983,969.00</u>	<u>363,616,800.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>289,983,969.00</u>	<u>363,616,800.00</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	309,350,200.00

131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	309,350,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	259,226,600.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,557,369.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,557,369.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	26,200,000.00	54,266,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	26,200,000.00	54,266,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	289,983,969.00	323,049,401.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	289,983,969.00	323,049,401.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	278,433,907.00	309,652,759.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	204,713,907.00	220,446,264.00
210101	Үндсэн цалин	125,493,080.00	158,739,476.00
210102	Нэмэгдэл	51,714,571.00	46,991,647.00
210104	Урамшуулал	11,173,749.00	14,715,141.00
210105	Гэрээт ажлын хөлс	16,332,507.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,058,323.00	27,185,514.00
210201	Тэтгэврийн даатгал	18,220,327.87	19,381,114.79
210202	Тэтгэмжийн даатгал	1,221,072.97	2,878,774.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	977,158.36	1,394,761.74
210204	Ажилгүйдлийн даатгал	187,364.18	288,597.42
210205	Эрүүл мэндийн даатгал	3,452,399.62	3,242,265.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,494,678.00	25,419,356.00
210301	Гэрэл, цахилгаан	1,957,678.00	2,398,356.00
210302	Түлш, халаалт	23,447,000.00	22,921,000.00
210303	Цэвэр, бохир ус	90,000.00	100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,827,409.00	00.00
210401	Бичиг хэрэг	286,869.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	1,913,840.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	367,000.00	00.00
210404	Ном, хэвлэл	240,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	794,200.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,225,500.00	00.00
2105	Нормативт зардал	12,550,290.00	21,763,475.00
210502	Хоол, хүнс	11,844,290.00	21,763,475.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	706,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,200,000.00	699,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,500,000.00	00.00
210604	Урсгал засвар	700,000.00	699,500.00
2107	Томилолт, зочны зардал	241,600.00	00.00
210702	Дотоод албан томилолт	241,600.00	00.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,723,000.00	1,504,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,150,000.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	108,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	465,000.00	1,504,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,624,700.00	12,634,650.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	10,374,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,624,700.00	2,260,550.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,550,062.00	13,396,642.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,113,800.00	12,788,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,713,800.00	9,458,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,000.00	3,330,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,436,262.00	608,442.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,436,262.00	608,442.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	40,567,399.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	6,143,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	6,143,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	6,143,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	6,143,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-6,143,500.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	34,423,899.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	34,423,899.00

2.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	27,294,031.95	111,842,888.67	97,059,916.37	236,196,836.99
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00

C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	27,294,031.95	111,842,888.67	97,059,916.37	236,196,836.99
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-25,667,651.00	-25,667,651.00
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	48,366,231.95	372,317,237.15	161,295,267.86	581,978,736.96
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	48,366,231.95	372,317,237.15	161,295,267.86	581,978,736.96
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	48,366,231.95	372,317,237.15	161,295,267.86	581,978,736.96
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	787,032.01	787,032.01
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	48,366,231.95	372,317,237.15	162,082,299.87	582,765,768.97

2.5. Аудит хийсэн улсын төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	309,350,200.00	274,926,301.00	34,423,899.00	88.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	309,350,200.00	274,926,301.00	34,423,899.00	88.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	295,538,600.00	262,138,101.00	33,400,499.00	88.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	215,924,300.00	195,951,840.00	19,972,460.00	90.75
210101	Үндсэн цалин	166,540,800.00	139,823,314.00	26,717,486.00	83.96
210102	Нэмэгдэл	41,813,500.00	43,209,947.00	-1,396,447.00	103.34
210104	Урамшуулал	7,570,000.00	12,918,579.00	-5,348,579.00	170.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,990,400.00	24,140,636.00	2,849,764.00	89.44
210201	Тэтгэврийн даатгал	18,353,500.00	17,299,096.70	1,054,403.30	94.26
210202	Тэтгэмжийн даатгал	2,159,200.00	2,633,736.94	-474,536.94	121.98

210203	ҮОМШӨ-ний даатгал	1,727,400.00	1,198,791.90	528,608.10	69.40
210204	Ажилгүйдлийн даатгал	431,800.00	241,083.54	190,716.46	55.83
210205	Эрүүл мэндийн даатгал	4,318,500.00	2,767,926.92	1,550,573.08	64.09
2105	Нормативт зардал	29,112,200.00	21,763,475.00	7,348,725.00	74.76
210502	Хоол, хүнс	29,112,200.00	21,763,475.00	7,348,725.00	74.76
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,511,800.00	1,504,000.00	7,800.00	99.48
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,511,800.00	1,504,000.00	7,800.00	99.48
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,999,900.00	18,778,150.00	3,221,750.00	85.36
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,605,200.00	16,392,100.00	3,213,100.00	83.61
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,394,700.00	2,386,050.00	8,650.00	99.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,811,600.00	12,788,200.00	1,023,400.00	92.59
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,811,600.00	12,788,200.00	1,023,400.00	92.59
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,472,500.00	9,458,200.00	1,014,300.00	90.31
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,339,100.00	3,330,000.00	9,100.00	99.73
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	309,350,200.00	309,350,200.00	0.00	100.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	306,800,200.00	306,800,200.00	0.00	100.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	306,800,200.00	306,800,200.00	0.00	100.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,550,000.00	2,550,000.00	0.00	100.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,550,000.00	2,550,000.00	0.00	100.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0	0.00	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	34,423,899.00	34,423,899.00	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	19.00	19.00	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	8.00	8.00	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	10.00	10.00	0.00	100.00

2.6. Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	54,266,600.00	53,658,158.00	608,442.00	98.88

21	УРСГАЛ ЗАРДАЛ	54,266,600.00	53,658,158.00	608,442.00	98.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	54,266,600.00	53,658,158.00	608,442.00	98.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	24,948,000.00	24,494,424.00	453,576.00	98.18
210101	Үндсэн цалин	24,948,000.00	18,916,162.00	6,031,838.00	75.82
210102	Нэмэгдэл	0	3,781,700.00	-3,781,700.00	
210104	Урамшуулал	0	1,796,562.00	-1,796,562.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,118,600.00	3,044,878.00	73,722.00	97.64
210201	Тэтгэврийн даатгал	2,120,500.00	2,082,018.09	38,481.91	98.19
210202	Тэтгэмжийн даатгал	249,600.00	245,037.29	4,562.71	98.17
210203	ҮОМШӨ-ний даатгал	199,600.00	195,969.84	3,630.16	98.18
210204	Ажилгүйдлийн даатгал	50,000.00	47,513.88	2,486.12	95.03
210205	Эрүүл мэндийн даатгал	498,900.00	474,338.90	24,561.10	95.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,500,000.00	25,419,356.00	80,644.00	99.68
210301	Гэрэл, цахилгаан	2,400,000.00	2,398,356.00	1,644.00	99.93
210302	Түлш, халаалт	23,000,000.00	22,921,000.00	79,000.00	99.66
210303	Цэвэр, бохир ус	100,000.00	100,000.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	700,000.00	699,500.00	500.00	99.93
210604	Урсгал засвар	700,000.00	699,500.00	500.00	99.93
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	54,266,600.00	54,266,600.00	0.00	100.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	54,266,600.00	54,266,600.00	0.00	100.00
320001	Орон нутгийн төсвөөс	54,266,600.00	54,266,600.00	0.00	100.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тэс сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь 2022 оны хичээлийн жилд сургалтын чанарыг сайжруулж багшийн онолын мэдлэг, арга зүй, ур чадварыг ахиулж сурагчдын авьяас сонирхлыг хөгжүүлж зөв хүн болгон хөгжүүлэх, эх хэлээрээ алдаагүй зөв ярих, бичих, сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх, өөрийн нутгийн ёс заншлаа мэдэж, хүндэтгэх хүмүүжилд сургах зорилго тавьж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн хувьд:

1. Боловсролын тухай хууль
2. Бага дунд боловсролын тухай хууль
3. Төсвийн тухай хууль
4. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
5. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
6. Шилэн дансны тухай хууль
7. Хөдөлмөрийн тухай хууль

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль -2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр
- ✓ Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"
- ✓ Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 276 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт
- ✓ Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт
- ✓ Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал "Албан томилолтын зардлын тариф" тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тэс сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Тэс сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 787.1 мянган төгрөгөөр буюу 1.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	34,423.9	34,423.9
Авлага	215.8	0.0	-215.8
Бараа материал	48,187.0	48,982.4	795.4
Үндсэн хөрөнгө	533,575.9	499,359.5	-34,216.4
Нийт хөрөнгө	581,978.7	582,765.8	787.1
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	581,978.7	582,765.8	787.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	581,978.7	582,765.8	787.1

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 34,423.9 мянган төгрөг байгаа нь зарцуулагдаагүй үлдэгдлийг төвлөрүүлээгүйгээс шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэлгүй болж 215.8 мянган төгрөгийн авлагыг барагдуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 48,982.4 мянган төгрөг болж 795.4 мянган төгрөгөөр өссөн нь хүнсний болон бичиг хэргийн материалын худалдан авч нөөцөлснөөс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 499,359.5 мянган төгрөг болж 34.216.4 мянган төгрөгөөр буурсан нь машин тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, бусад үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан, хөрөнгийн хуримтлагдсан элэгдлээс шалтгаалж буурсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 582,765.8 мянган төгрөг болж 787.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 367,800.0 мянган орон нутгийн төсвөөс 54,200.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсвөөс 23,900.0 мянга, орон нутгийн төсвөөс санхүүжих зардлыг 541.8 мянган төгрөгийг хасаж баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт тодотголоор өөрчлөлт ороогүй байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 343,900.0 мянга, орон нутгийн төсвөөс 54,200.0 мянган төгрөг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 309,350.2 мянга, орон нутгийн төсвөөс 53,658.2 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 328,584.5 мянган төгрөг буюу 96.3 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 12,587.6 мянган төгрөг дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Ерөнхий боловсрол -71802 Байр ашиглалтын үйлчилгээ-80226	279.0	251.3	27.7	90.1
2	Ерөнхий боловсрол 71802 Сургалт семинар - 80312	139.5	139.0	0.5	99.6
3	Эрүүл мэндийг дэмжих-81605	684,2	616,0	68,2	90.0
4	Үдийн цай хөтөлбөр-81801	10,472.5	9,458.2	1,014.3	90.3

5	Дотуур байрны үйлчилгээ-81806	48,992.3	38,024.5	10,967.7	77.6
6	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин-81816	7,495.0	4,488.0	3,007.0	59.8
7	Боловсролын байгууллагын багш-81823	1,379.4	1,288.0	91.4	93.3
8	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө -81834	179,630.0	164,238.9	15,391.1	91.4
9	Сургалтын хэвийн үйл ажиллагаа хангах	57,728.3	53,874.1	3,854.1	93.3
10	Нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан	2,550.0	2,548.3	1.7	99.9
11	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал-80111	26,200.0	26,118.8	81.1	99.6
12	Нийтлэг үйлчилгээ	28,066.6	27,539.3	527.3	98.1

Цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал нь албан хаагчид өвчтэй, чөлөөтэй байсан зэргээс шалтгаалан 23,349.5 мянга, хоолны зардлаас 7,348.7 мянга, байр ашиглалттай холбоотой зардал 80.6 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал 1,014.3 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 3,221.7 мянган төгрөгийг Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнтэй холбоотойгоор тус тус хэмнэсэн байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тэс сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Тэс сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор С.Алтанхундага гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Тэс сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 315,978.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 3,159.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 363,757.3 төгрөгийн 1 хувиар буюу 3,637.6 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Тэс сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн хувьд хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд биет горим сорилыг хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно. /АБ-4/

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 166 мэдээллээс, хугацаа хоцроож мэдээлсэн 77, мэдээлэл байршуулаагүй 25, хугацаандаа мэдээлсэн 64 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Тэс сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны сайтад 8 гүйлгээг байршуулаагүй алдаа, зөрчилд албан шаардлага өгсөн, тайланд онд 77 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 25 мэдээллийг байршуулаагүй, 363,096.8 мянган төгрөгийн 33 гүйлгээг байршуулаагүй зөрчилд хариуцлага тооцуулах албан шаардлага өглөө.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тэс сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар бичнэ.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	161,746.2	1	161,746.2	100
Зөвлөмж					
Нийт дүн	1	161,746.2	1	161,746.2	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тэс сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн хувьд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 363,096.8 мянган төгрөгийн 1 алдаа зөрчил илэрсэнд албан шаардлага өглөө.

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тэс сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны сайтад 8 гүйлгээг байршуулаагүй алдаа, зөрчлийн арилгуулах албан шаардлага өгснийг хэрэгжүүлэн ажиллаагүй, тайланд онд 77 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 25 мэдээллийг байршуулаагүй, 363,096.8 мянган төгрөгийн 33 гүйлгээг байршуулаагүй байсанд сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага өглөө.

Дээрх албан шаардлагын биелэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								

шилэн дансны цахим хуудаст мэдээлээгүй.	1	363,096.8		1	363,096.8		
Дүн	1	363,096.8		1	363,096.8		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил							
Дүн							
Нийт дүн							

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЫ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

ГЭРЭЭТ АУДИТОР  /С.АЛТАНХУНДАГА/

2023 оны 02 дугаар сарын 23-ны өдөр

**АЛБАН ШААРДЛАГЫН БҮРТГЭЛ,
ХЯНАЛТЫН ХУУДАС**

А. Албан шаардлагын төсөл бэлтгэж, баталгаажуулах үеийн бүртгэл, хяналт

1 Ерөнхий мэдээлэл

1.1 Аудитын нэр	Тэс сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн тайлангийн аудит	1.2 Аудитын код	УВА-2023/149/НА-СТА-ТШЗ
-----------------	--	-----------------	-------------------------

1.3 Аудит хийсэн үндэслэл	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын газрын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд	1.4 Аудитын төрөл	Санхүүгийн тайлангийн аудит
---------------------------	--	-------------------	-----------------------------

1.5 Албан шаардлагын дугаар	01/13/A2050409 УВА-2023/149/НА-ЭТА-ТШЗ	1.6 Огноо	2023.02.24	1.7 Мөнгөн дүн /төгрөгөөр/	363,096,800
-----------------------------	---	-----------	------------	----------------------------	-------------

1.8 Албан шаардлага өгөх үндэслэл	Алдаа, зөрчлийн товч утга	Тэс сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь нь өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны сайтад 161,746.2 мянган төгрөгийн 10 гүйлгээг байршуулаагүй зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгснийг хэрэгжүүлэн ажиллаагүй, тайланд онд 77 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 363,096.8 мянган төгрөгийн 58 мэдээллийг байршуулаагүй байна.		
	Алдаа, зөрчлийн ангилал	Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой.		
	Журмын заалт (4.2-оос аль тохирохыг оруулах)	4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"		
	Зөрчсөн эрх зүйн актын	Нэр	Шилэн дансны тухай хууль,	
		Заалт	Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг 7 хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5 дахь заалтад "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 дахь заалтад "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр"	
Үндэслэл болгосон	Нэр	Төрийн аудитын тухай хууль		

	эрх зүйн актын	Заалт	Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь заалтад "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ
		Нэр	Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам
		Заалт	Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"

1.9 Төлбөр барагдуулах хэлбэр /Төгрөгөөр/	Улсын төсвийн дансанд	-	1.10 Төлбөр, зөрчил барагдуулах огноо
	Орон нутгийн төсвийн дансанд	-	
	Тухайн байгууллагын дансанд	0.00	
			2023-03-30

2. Үндэслэл болгосон гол нотлох баримтын талаарх мэдээлэл

№	Нотлох баримтын нэр төрөл	Дугаар	Огноо	Тайлбар
1	Шилэн дансны цахим мэдээлэл			Шилэн дансны сайтад байршуулсан
2				

3. Аудитын баг болон хариуцагчийн талаарх мэдээлэл

№	Аудитын багийн		Хариуцагч			
	Овог нэр	Албан тушаал	Байгууллагын нэр	Албан тушаал	Овог нэр	Холбоо барих хаяг, утас
1	М.Батсуурь	Дарга, тэргүүлэх аудитор	Тэс сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн	захирал	Д.Хандаа	80662085
2	М.Бат-Амгалан	Аудитын менежер		Нягтлан бодогч	Н.Уранчимэг	99022495
	С.Алтанхундага	Гэрээт аудитор				

4. Албан шаардлага бэлтгэх үеийн чанарын хяналт

4.1 Чанарын хяналт хийсэн тэмдэглэл

№	Албан тушаалтан	Огноо	Чанарын хяналтаар өгсөн санал зөвлөмж
1	Дарга, тэргүүлэх аудитор	2023.02.24	—
2	Аудитын менежер	2023.02.24	—



4.2 Албан шаардлагыг хэвлэмэл хуудсанд хэвлэх зөвшөөрөл

№	Албан тушаал	Овог нэр	Огноо
1	Дарга, тэргүүлэх аудитор	М.Батсуурь	2023-02-24



5. Албан шаардлагыг баталгаажуулж, хүргүүлэх үеийн баримтжуулалт

№	Үзүүлэлт	Мэдээлэл оруулах хэсэг	Тайлбар	
1	Албан шаардлагыг баталгаажуулсан тушаалын	Огноо		
		Дугаар		
2	Албан шаардлагыг хүргүүлсэн албан бичгийн	Огноо		
		Дугаар		
3	Албан шаардлагыг хүлээлгэн өгсөн	Огноо		
		Ажилтны	Овог нэр	С.Алтанхундага
			Албан тушаал	Гэрээт аудитор
4	Албан шаардлагыг хүлээн авсан	Байгууллагын нэр		Тэс сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль
		Ажилтны	Овог нэр	Н.Уранчимэг
			Албан тушаал	Нягтлан бодогч
5	Албан шаардлагын хэрэгжилтийг хариуцах	Газрын нэр		Увс аймаг дахь Төрийн аудитын газар
		Ажилтны	Овог нэр	С.Алтанхундага
			Албан тушаал	Гэрээт аудитор
6	Тооцоолсон зөвшөөрүүлсэн үр өгөөж	Санхүүгийн	Тоо	
			Дүн	
		Санхүүгийн бус үр өгөөжийн тоо		1



УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 01113/А 2050409
УВА-2023/149/НА-СТА ФЦУЗ

Улаангом

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Тэс сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тэс сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны сайтад 161,746.2 мянган төгрөгийн 10 гүйлгээг байршуулаагүй зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгснийг хэрэгжүүлэн ажиллаагүй, тайланд онд 77 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 363,096.8 мянган төгрөгийн 58 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг 7 хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.5 дахь заалтад “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 дахь заалтад “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь заалтад “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ” гэсэн заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг мөрдөн ажиллаагүй, зөрчлийг давтан гаргасан нягтлан бодогч Н.Уранчимэгт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт² ирүүлэхийг Тэс сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн захирал Ж.Оюун, Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн захирал Д.Хандаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ГЭРЭЭТ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.АЛТАНХУНДАГА

М.БАТ-АМГАЛАН

М.БАТСУУРЬ

²Увс аймаг, Улаангом сум, 3 дугаар баг, Ө.Бадрахын гудамж, аймгийн Засаг Даргын Тамгын газрын байр, 304 тоот, Утас: 70453317

0200400048